

**МОНГОЛ, АНГЛИ ЗҮЙР ЦЭЦЭН ҮГЭНД  
ЭМЭГТЭЙ ХҮНИЙ ҮНЭЛЭМЖ ИЛРЭХ НЬ**

**Б. Мөнхцоож \***

**Түлхүүр үгс:** *зүйр цэцэн үг, үнэлэмж, эерэг үнэлэмж, сөрөг үнэлэмж*

Ардын аман зохиол бол гүн ухаан, ертөнцийг үзэх үзэл, түүх сурган хүмүүжүүлэхүй, ёс суртахуун, зан заншил, шашин урлаг зэргийн үүргийг гүйцэтгэж байдаг оюуны соёлын нэгдмэл хэлбэр<sup>1</sup> ба тухайн үндэстний ертөнцийг үзэх үзэл, ертөнцийг таньсан танилт нь чухамдаа юм үзэгдэл, үйл явдал, шинж чанар, нөхцөл байдлыг тогтсон хэмжүүр, тогтсон үнэлэмжээр айчлан хураангуйлж оюун ухаандаа шингээсэн байдаг учраас түүнийг илэрхийлэх хэлний арга хэрэглүүр нь бас л аль болох маш цомхон, хураангуй хэлбэр бүтцийг ашиглах нь зайлшгүй зүй тогтолт үзэгдэл юм. Энэ нь даруй зүйр цэцэн үг, өвөрмөц хэллэг зэрэг тогтвортой хам бүтэц юм.<sup>2</sup> Үнэлэмжийн тухай мэдлэгийг бие даасан салбар болгох эхлэлийг Германы философич Рудольф Херман Лотце (1817-1881) тавьсан гэж үздэг ба тэрээр “үнэлэмж бол бидний хүсэл эрмэлзлэлээс огт хамааралгүй байдаг боловч бидний мэдрэмж рүү хандаж, тухайн тодорхой мэдрэмж нь янз бүрийн үнэлэмжийн зохих хязгаарыг тогтоож байдаг”<sup>3</sup> гэж бичжээ.

Үнэлэмж (англиар “value”, оросоор “оценочность”) нь нийгэм болон хүнд сайн муу, сайхан муухай, шударга ба шударга бус, үнэн ба худал, туйлын ба харьцангуй гэх мэт ойлголтуудыг ялгахад тусалдаг ба цаг хугацаа, нийгмийн хөгжил, ёс заншил, шашин шүтлэг, уламжлал зэргээс хамаарч байнга өөрчлөгддөг. Хүн өөрийгөө болон хүрээлэн буй орчноо танин мэдэх, тэдгээртэй нийцэж амьдрах, хорвоогийн зүй тогтол, амьдралын дотоод мөн чанарыг ойлгож ухаарах гэсэн эрэл хайгуулын явцдаа тэдгээрээс оюун дүгнэлт хийж, хүн нийгмийн зөв, буруу дадал зуршил, гүн ухаан, хууль зүй, нийгэм, улс төр, ёс суртахуун, гоо зүй, хүмүүжил, соёл боловсрол, мэдлэг, сүсэг бишрэл, хураангуйлж хэлбэл бараг хамраагүй сэдэв ер үгүй<sup>4</sup> өргөн санаа агуулсан цэцэлсэн, зүйрлэсэн, сургамжилсан өнгө аяс бүхий зүйр цэцэн үг нь ард түмний үнэлэмжийн нэг илэрхийлэл юм.

\* “Гурван Эрдэнэ” БДС-ийн багш

<sup>1</sup>) Ш.Гаадамба, Х.Сампилдэндэв “Монгол ардын аман зохиол”. УБ., 1988. 33-р тал

<sup>2</sup>) Ж.Баянсан “Соёл хэл үндэстний сэтгэлгээ” УБ., 2002. 99-р тал

<sup>3</sup>) Л.Одонтуяа “Үнэлэмж сэтгэлгээний илрэл болох нь” ХИС, ЭШБ, 2004 .61-р тал

<sup>4</sup>) Цэрэнсодном.Д., Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг, УБ, 2011, 49

Жеэндэрийн хэл шинжлэл нь 1960-аад оны үед Америкийн Нэгдсэн Улсад бий болсон хэлийг шүүмжлэх феминист үзэлтэй холбоотой гарч ирсэн хүн төвт хэл шинжлэл (anthropological linguistic) юм. Бидний судалгааны ажил монгол, англи зүйр цэцэн үгэнд эрэгтэй эмэгтэй хүмүүстэй холбоотой бий болсон үг хэллэг, өөрчлөлтүүдийг хэл-соёл, жеэндер судлалын үүднээс тайлбарлахад чиглэгдэж байгаа бөгөөд энэ удаад монгол, англи зүйр цэцэн үгэнд эмэгтэй хүнийг үнэлэх үнэлэмж хэрхэн илэрсэнд бэсрэг судалгаа хийхдээ сайн, муу гэсэн ерөнхий үнэлэмжийг барьж эмэгтэй хүнийг үнэлэх **эерэг** болон **сөрөг** үнэлэмж хэрхэн илэрснийг гаргахыг зорилоо.

*Эмээл морины чимэг, Эхнэр амьдралын чимэг, Сайхан хүүхэн гэрийн чимэг, Саглагар мод уулын чимэг* хэмээн эмэгтэй хүний гоо үзэмжийг таашаан өгүүлэхийн сацуу эхнэр хүн ажилтай арчаатай байж *Авгайн сайнаар амь зууж Аргамжийн сайнаар ачаа ачиж* жин хөсөг тээж холыг ойртуулж, мал аж ахуйгаа эрхэлж явсан нүүдэлчин монголчуудын хувьд *Эргээд буухад ээж сайхан, Эргүүлж мөлжихөд хүзүү сайхан, Буурал ээжийн сургаал үнэтэй, Бултын нийлсэн гар хүчтэй* хэмээн эмэгтэй хүнийг, ээжээ эрхэмлэн дээдэлсэн эерэг үнэлэмж олон байна. Амьдралын жам ёсоор хорвоогийн мөнх бусыг үзэхэд *Эхт өнчин өөдөө, Эцэгт өнчин уруугаа* гэсэн нь үр хүүхдээ халамжлан анхаарах талдаа эмэгтэй хүн эр хүнээс хавьгүй илүү гэсэн санааг лавшруулан *Эр хүн өрхөө татахдаа Хэнийг авахаа бодох Эм хүн өрхөөн татахдаа Хэрхэн амьдрахаа бодох* гэсэн зүйр үгс байдаг нь эмэгтэй хүний эрхэм сайхан чанаруудыг эерэг сайнаар үнэлсэн үнэлэмжийн илрэл юм.

Англи зүйр цэцэн үгэнд эмэгтэй хүнийг бурхантай зүйрлэн *God couldn't be everywhere and therefore he made mothers* -үгчилбэл *Бурхан хаа сайгүй байж чадахгүй учраас ээжүүдийг бүтээсэн* гээд эмэгтэй хүүхэд эрэгтэй хүүхдийг бодвол ээж аавдаа илүү ойр дотно байдаг тухайд *A son is a son till gets him a wife, a daughter is a daughter all her life-* *Эрэгтэй хүүхэд эхнэр автлаа хүү нь байдаг бол эмэгтэй хүүхэд харин насан туршдаа охин нь байдаг* хэмээжээ. Эмэгтэй хүний гоо үзэмж, сайхны тухайд *A good surgeon has an eagle's eye, lion's heart, and lady's hands-* үгчилбэл *Сайн мэс засалч хүн бүргэдийн нүд, арслангийн зүрх, залуу бүсгүйн гартай* байдаг. *A clever woman is far more precious than jewels, intelligence and dignity are her clothing-* *Ухаалаг эмэгтэй эрдэнэсээс илүү үнэтэй, оюун ухаан, намба төрх нь түүнийг чимдэг* гэсэн нь монгол хэлний эдээр биеэ чимэхээр эрдмээр биеэ чим гэсэн хэллэгтэй утга дүйж байна. Эмэгтэй хүн амьдралын хатуу хөтүүг үүрэхдээ эр хүнээс илүү тухайд *Eight lives for the men and nine for the women-* *Эр хүн найман удаа, эм хүн есөн удаа амьдарна* гэжээ. Мөн түүнчлэн *Behind the successful man there is a smart woman* буюу *Амжилттай эрэгтэйн ард ухаалаг эмэгтэй байдаг* гэсэн зүйр цэцэн үгээс харвал эрэгтэй хүний амжилттай, өөдрөг, бүтэмжтэй яваад эмэгтэй хүний эрдэм ухаан бас тодорхой үүрэгтэй тухай өгүүлсэн нь монгол хэлний *Ганц хүн айл болдоггүй, Ганц мод гал болдоггүй; Эрийн нэрээр орж, Эмийн нэрээр гарна* гэсэн зүйр цэцэн үгстэй утга төстэй юм. *Woman is the neck that turns the head* буюу *Эмэгтэй хүн бол толгойг хөдөлгөх хүзүү юм* гэсэн зүйр үгийн “хүзүү” гэдэг эрхтнийг анатомынх нь талаас тайлбарлавал уртавтар тархины доороос шууд үргэлжлэх найман үелэлт нугас ба төв мэдрэлийн эрхтнийг бүрэлдүүлэгч мэдрэлийн гуурсны хувьд зөвхөн чиглүүлэх төдийгүй төв мэдрэлийн эрхтний нэг гэдгээр нь авч үзвэл эмэгтэй хүн бол аливаад шийдвэрлэх үүрэгтэй оролцдог гэсэн санаа байна.

Монгол зүйр цэцэн үгэнд орон гэрээ өнгөтэй өөдтэй авч явж чаддаггүй залхуу, ажил үйл муутай эхнэрийн тухайд *Үйлгүй хүүхэн дууламхай Сүүгүй үнээ мөөрөмхий, Аальгүй*

хүүхэн инээмтгий *Ажилгүй хүүхэн унтамтгай, Ажилгүй эмд анхны хүүхэд шалтаг* гэж өгүүлсэн ба ерөөс аальгүй хүүхэн гэдэг ойлголт эмэгтэй хүнийг үнэлэх сөрөг үнэлэмжийн нэг гэдгийг *Аальгүй хүүхэн Аяга шаазан дээгүүр, Аальгүй хүүхэн нүдээрээ даллана Агсруун бух сүүлээрээн даллана, Аальгүй хүүхэн үгэнд унах Агсам морь нүхэнд унах, Аальгүй хүүхний зааранд Авиргүй харцуул мансуурах* зэрэг зүйр цэцэн үгсээс харж болно.

Эрэгтэйчүүдийн их, бага тархины аль нэг нь ажиллаж байхад нөгөө нь амарч бодох, бясалгах нь их байдаг бол эмэгтэйчүүдийн хоёр тархи зэрэг ажиллаж бодох, хийх нь зэрэг явагдана. Эрэгтэй хүн өдөрт дунджаар долоон мянган үг хэлэх чадвартай бол эмэгтэй хүнд хорин мянган үг хэлэх чадвар заяасан<sup>5</sup> нь биологийн онцлог мөн хэдий ч эмэгтэй хүний үглээ яншаа байдал, уйлагнаж улцагнах, хов жив хөөцөлдөх зан нь сөрөг үнэлэмж болдог байна. *Улин хуцах нохойн аюул Уйлагнан үглэх эмийн аюул, Хөгшин чавганц гэрийн ягшуур Хөгшин нохой хотны ягшуур, Хэлтгий газар буувал Нүүн нүүтлээ зовно Яншаа эхнэртэй суувал Үхэн үхтлээ зовно, Охин хүн амныхаа мууд Орог зусаг аашныхаа мууд, Олон хүүхэнтэй газар Хов тасрахгүй Олон ямаатай хонь Бэлчээрт тогтдоггүй* гэсэн зүйр цэцэн үгсэд эмэгтэй хүний ерөнхий зан чанарын сөрөг үнэлэмжийг тусгахын зэрэгцээ эелдэг зөөлөн, даруу төлөв, ухаалаг цэгцтэй бай гэсэн сургамжийг давхар агуулсан нь лавтай.

Анги нийгмийн ялгарал бий болохын хэрээр зүйр цэцэн үгсэд нийгмийн нөлөө тусгагдаж, илтгэх агуулга нь өөрчлөгдөн эмэгтэй хүнд хандах хандлага, үнэлэмж харилцан адилгүй байсныг дараах зүйр цэцэн үгсээс ажиглаж болно.

*Усун- у эки<sup>6</sup> булаг*

*Улус-ун эки ни нагачу.*

*Күмүн- ү уг нагачу*

*Модун- у уг үндүсү.*

*Над / ад / үгүй боловч*

*Нагацад буй*

гэх мэт зүйр цэцэн үгсэд эхийн эрхт ёсыг эрхэмлэн дээдэлсэн санаа агуулагдаж байгаа бол эхийн эрхт ёс халагдаж, эцгийн эрхт ёс ноёрхох болсон цаг дор эмэгтэй хүнд болон тэр дундаа хатан хүнд хандах хандлага хэрхэн өөрчлөгдсөнийг *Сайн ч болсон эм хүн Саруул ч болсон сэвтэй сар, Эр хүний хэлсэн тосон дээгүүр, Эм хүний хэлсэн усан доогуур* хэмээн “эмэгтэй хүн” гэх дорд үзлийг илэрхийлсэн бол морио дээдэлдэг монгол түмэн гүү унаж уралддаггүйтэй адил эм хүнтэй ярилцаж шийдвэр гаргадаггүй тухай *Эм хүнтэй хэлэлцдэггүй Гүү мориор уралддаггүй* гэх мэтээр өгүүлэхийн сацуу *Алба мэдэхгүй ноён Улсын чөтгөр Ааш муутай хатан Төрийн чөтгөр; Тэмээн толгой Тэвшинд багтахгүй Тэнтгэр хатан Зарга шүүхгүй, Ямаан толгой Ямбанд орохгүй Янтгар хатан Зарга шүүхгүй* гэсэн нь тэмээ, ямааны мах сэрүүн чанарын янтай мах

<sup>5</sup>) Х.Сүхбаатар “Ялгагдахуй буюу хос хууль” [http://amjilt\\_0247.blog.gogo.mn](http://amjilt_0247.blog.gogo.mn)

<sup>6</sup>) Монголчууд эхийн эрхт ёсны эрхшээлд байх үедээ төрөл садан буюу нэг овог төрөлд хамаатай гэдгээ “Кэкэми никэтэн, Кэкэ гагчатан” гэдэг цэцэн үгээр илэрхийлж байсан бололтой. Монгол хэлний “кэкэ” гэсэн үг бидний барагцаалснаар эрт балар эхийн эрхт ёсны үед ийм дуудлагатай байгаад улмаар “экэ” болж хувирсан байх. Учир нь “эки” буюу “эхи” гэсэн үгийг мөн “Нууц товчоо”-нд заримдаа “эки” /& 46/, заримдаа “экэ” /& 81/ гэх зэргээр янз янзаар бичсэн байна. Энэ “эки” гэсэн үг маш эртний нэгэн цагт “кэки” гэсэн дуудлагатай байсан байж ч болно гэжээ. (“МНТ” монголын аман зохиолд холбогдох асуудалд. М.Гаадамба. Монголын судлал. УБ.,1971. Т- VIII, 1-25. 32-р тал ).

учраас ямбаны зоогт ордоггүй шиг хатан хүн ноёны эхнэр хэдий ч эрх мэдэл нь ноёны хэмжээнд хүрэхгүй гэсэн үндсэн санааны хажуугаар ааш аяг муутай, гоо үзэмж тааруу зарим хатдыг “янтгар”, “тэнтгэр” хэмээн сөрөг үнэлэмж бүхий үгсээр илэрхийлсэн байж болох юм.

Монгол зүйр цэцэн үгэнд эмэгтэй хүний тухай сөрөг үнэлэмжийг гаргахдаа эрхэлдэг мал аж ахуйнхаа таагүй зохицлын илрэл болсон *сүүгүй үнээ, агсруун бух, агсам морь*, хүйтэн хошуутай мал болох *тэмээ, ямааны толгой*, нүүдэлчин монголчуудын үнэнч анд нохойны муу шинж гэгдэх *улин хуцдаг нохой, сэвтэй сартай* зэрэгцүүлэн гаргасан бол англи зүйр цэцэн үгэн дэх эмэгтэй хүний сөрөг үнэлэмж нь *ууртай хэдгэнэ, хуйсагнуур салхи, зөрүүд гахай, орилоо тахиатай* зүйрлэгдсэн нь элбэг буюу эмэгтэй хүнийг хамгийн муу муухайн жишиг хэмжүүр болсон *чөтгөртэй* адилтгаж *итгэхэд бэрх* гэсэн нь олон байна.

Цэвэр цусны хурдан үүлдрийн адуугаараа алдартай, морин уралдаанд дуртай англичуудын хувьд олон мянган жилийн турш тэдэнд хамгийн ойр байсан амьтан бол яахын аргагүй адуу. Адууг хоргоон довтолж зовоодог олон зүйлийн шавьжнаас хамгийн хэцүү нь гэгдэх *хэдгэнийг* эмэгтэй хүний сөрөг муу үнэлэмжийн илэрхийлэл болгон *Women are like wasps in their anger- Эмэгтэйчүүд ууртай хэдгэнэтэй адил* гэсэн бол тогтворгүй хувьсамтгайн жишиг хэмжүүр болсон салхийг эмэгтэй хүний ааш араншинтай зүйрлүүлэн *Women are as wavering as the wind- Эмэгтэйчүүд салхи шиг тогтворгүй; Woman's character is like wind- Эм хүний ааш авир яг салхи шиг* гэсэн нь монгол хэлний *хаврын тэнгэр шиг ааштай* гэсэн хэллэгтэй утга ижил юм. Эмэгтэй хүн ухаан муутай гэсэн сөрөг үнэлэмжийг *A dog is wiser than a woman it doesn't bark at its master- үгчилбэл Нохой, эм хүнээс илүү ухаантай учир нь хэзээ ч эзэн рүүгээ дайрдаггүй* гэж илэрхийлжээ. Мөн *Эмэгтэй хүний үс урт, ухаан богино- Women have long hair and short brains* гэсэн хэллэг монгол англи хэлэнд яв цав таарч байна. Бурхантай зүйрлэгдэн хэлэгдэж байсан эмэгтэй хүнийг чөтгөртэй адилтган *There is no devil so bad as a she devil- Эмэгтэй хүн шиг чөтгөр гэж үгүй; Women are the devil's net- Эмэгтэйчүүд бол чөтгөрийн тор* хэмээн хэлсэн нь сайн муу, сайхан муухайгаар дүүрдэг нүд шиг алаг хорвоод эерэг сайн нь олон байгаасай, ерөөс хүн гэдэг амьтан буруу, муу зан авир, үйл явдлаа засч яв хэмээн сургамжилсан нь гарцаагүй. Дээр өгүүлсэн *Улин хуцах нохойн аюул Уйлагнан үглэх эмийн аюул* гэсэн монгол зүйр цэцэн үгтэй ижил утга санааг англичууд, эрхэлж ирсэн уламжлалт аж ахуйнхаа нэг “тахиа”-ны муу шинжтэй зүйрлэн *A whistling woman and a crowing hen will bring no luck to the house they are in- Исгэрэгч эм, орилох эм тахиа гэр орондоо гай зовлон авчирна* хэмээн өгүүлжээ. Англичуудын хувьд “гахай”-г бохир заваанаас гадна зөрүүд, мунхаг гэсэн сөрөг үнэлэмжтэй адилтгал нэлээд байдгийн нэг жишээ нь *Swine, women and bees are not to be turned- Гахай, эмэгтэйчүүд, зөгий гурав эргэдэггүй* гэсэн хэллэг юм. Энд зөрүүд гахай, цэцгэнд шунан тэр чигээрээ зүтгэх зөгийн шинжийг эмэгтэй хүний гөжүүд зан авиртай зэрэгцүүлэн илэрхийлсэн байна. Англи зүйр цэцэн үгэнд эмэгтэй хүнд хэзээ ч итгэж болохгүй гэсэн утга элбэг тохиолдоно. Үүнийг *It's difficult to trust woman* Эмэгтэй хүнд итгэхэд бэрх, *Never trust a woman, even if she has born you seven* Чамд долоон хүүхэд төрүүлж өгсөн ч эм хүнд бүү итгэ гэсэн хэллэгээс ажиглаж болно. Эмэгтэй хүний сөрөг үнэлэмж болох ховч, атаархуу ааш араншинг илэрхийлэхдээ *A woman never praises another- үгчилбэл Эмэгтэй хүн эмэгтэй хүнээ хэзээ ч магтдаггүй* буюу монгол хэлний *Олон хүүхэнтэй газар хов тасардаггүй* хэмээн хэлжээ. Бэлэн зэлэн үгтэй хүн хачир дээрээ ажил муутай

нэгэн байдаг талаар англи, монгол хүний үнэлэмж төстэй нь *The tongue of the idle woman is never idle* буюу *Ажилгүй эмийн ам завгүй* гэх зүйр цэцэн үгээр илэрсэн байна.

Бидний судалж буй монгол, англи зүйр цэцэн үгэнд эмэгтэй хүний эерэг үнэлэмжийг царай зүсний сайхнаас илүүтэйгээр гэр орноо өнгөтэй өөдтэй авч явах ажилсаг байдал, эр нөхөртөө түшиг хань болсон ухаалаг зан чанараар түлхүү гаргасан бол сөрөг үнэлэмжийг, эрхэлдэг аж ахуй, мал амьтныхаа хамгийн зохицол муутай байдал төрхтэй зүйрлэн хэлжээ. Монгол зүйр цэцэн үгэнд эмэгтэй хүний сөрөг үнэлэмжийг илэрхийлэхэд хамгийн их давтамжтай орсон хэллэг нь “*аальгүй хүүхэн*”, “*үглээ, яншаа эм*” байгаа бол англи зүйр цэцэн үгэнд “*итгэхэд бэрх*”, “*чөтгөр шиг*” гэсэн хэллэг олонхи нь байна. Харин монгол зүйр цэцэн үгэнд эмэгтэй хүнийг чөтгөртэй зүйрлэсэн хэллэг байсангүй. *Эмэгтэй хүний үс урт ухаан богино, Олон хүүхэнтэй газар хов тасардаггүй, Ажилгүй эмийн ам завгүй* гэсэн хэллэг хоёр хэлэнд яв цав таарч байна. Эмэгтэй хүний тухай өгүүлсэн 258 монгол зүйр цэцэн үгийн 38.7 хувь нь эерэг, 62.3 хувь нь сөрөг үнэлэмж илэрхийлж байгаа бол 214 англи зүйр цэцэн үгийн 31.3 хувь нь эерэг, 69.7 хувь нь сөрөг үнэлэмж илэрхийлж байна.

## НОМ ЗҮЙ

### *Ишлэсэн сурвалж:*

1. Баянсан.Ж., Соёл хэл үндэстний сэтгэлгээ, УБ., 2002. 99-р тал
2. Гаадамба.М., Монголын судлал, УБ.,1971. Т- VIII, fask 1-25. 32-р тал
3. Гаадамба.Ш., Сампилдэндэв.Х., Монгол ардын аман зохиол, УБ., 1988. 33-р тал
4. Одонтуяа.Л., Үнэлэмж сэтгэлгээний илрэл болох нь ХИС, ЭШБ, 2004 .61-р тал
5. Х.Сүхбаатар.Х., Ялгагдахуй буюу хос хууль, [http://amjilt\\_0247.blog.gogo.mn](http://amjilt_0247.blog.gogo.mn) 2012.11.03
6. Цэрэнсодном.Д., Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг, УБ, 2011, 49-р тал

### *Ашигласан сурвалж:*

#### *Монгол хэлээр:*

1. Гаадамба.Ш., Цэрэнсодном.Д., Монгол ардын аман зохиолын дээж, УБ., 1973.
2. Дамдинсүрэн.Ц., Лувсандэндэв.А., Орос-Монгол толь, УБ., 1982.
3. Дамбасүрэн.Н., Монгол ардын зүйр үг, УБ.,1959.
4. Ж.Дашдорж.Ж., Рэнчинсамбуу.Г., Монгол зүйр цэцэн үгс,УБ., 2002.
5. Идэрбаяр.Б., Мянган зүйр цэцэн үгийн англи, орос, монгол толь, УБ., 2000.
6. Лувсанжав.Чой., Орос монгол өвөрмөц хэллэгийн толь,УБ., 1970.
7. Ням-Осор.Н.,Өлзийсүрэн.Б., Монгол хэлний зүйр, цэцэн үгийн товч тайлбар толь, УБ., 2011.
8. Өлзийхутаг.Ц., Монгол ардын оньсого цэцэн үг,УБ.,1982.

#### *Англи хэлээр:*

1. Apperson G.L., English proverbs and proverbial phrases., Lnd 1969.

2. Simpson, John. *The Concise Oxford Dictionary of Proverbs*. Oxford. 1992.
3. Taylor, Archer. *The proverb, and An index to The proverb*. Hatboro, Pa., Folklore Associates, 1962.
4. Wolfgang Mieder., *The Prentice-Hall encyclopedia of world proverbs: a treasury of wit and wisdom through the ages*. Englewood Cliffs, NJ: Prentice-Hall, 1986.
5. Wolfgang Mieder., *Proverbs are Never out of Season. Popular Wisdom in the Modern Age*. New York: Oxford University Press, 1993.

## **RESUME**

The positive value for the women in Mongolian and English proverbs are expressed as hardworking, intelligent, as well as good adviser and helper for their husband. These qualities are considered more valuable than beauty. Negative value for the women are shown connecting and comparing with bad harmony of their animal husbandry and farm. The expressions “fizgig” and “querulous woman” are more frequently for saying women’s bad qualities in Mongolian proverbs but in English “as devil” and “difficult to trust” is used more. In both Mongolian and English proverbs which are said about women negative value is more than positive one. 62.3 percentage of 258 Mongolian proverbs, 69.7 percentage of 214 English proverbs are expressed as negative value.